



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 6/18

Номгон

Г

Ажлын хэсэг байгуулах тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18, 45 дугаар зүйлийн 45.4, 48 дугаар зүйлийн 48.1, Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3.2, Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Нийтийн сонсгол зохион байгуулах журам”-ын 2.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Баянхонгор аймгийн хэмжээнд олгогдсон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын олборлолт ил тод байдал, гэрээний хэрэгжилт, үр дүн хяналт”, “Баянхонгор сумд олгогдсон өрхийн хэрэглээний 0.07га газар, инженер шугамд холбогдсон газар олголтын ил тод байдал”, “Утаа, агаарын бохирдол”-ын асуудлаар ерөнхий хяналтын сонсголд бэлтгэх, зохион байгуулах, цаашид авах арга хэмжээний талаар санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: С.Алтанцэцэг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зохион байгуулалт, олон нийттэй харилцах хэлтсийн дарга

Гишүүд С.Батцэрэн	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
Ц.Буянтогтох	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
Т.Баярмагнай	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
Д.Ёндондаш	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
Д.Юндэнбазар	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хууль эрх зүй, хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн
Б.Өлзийбат	“Иргэн та хүч” ТББ-ыг үүсгэн байгуулагч
Д.Нямсүрэн	Иргэний төлөөлөл
Л.Өсөхбаяр	Иргэний төлөөлөл

D;2025on;togtool2025

642501028

2. Сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох асуудлаар шийдвэр гаргуулах зэргээр холбогдох хууль журмын дагуу ерөнхий хяналтын сонсголыг 2025 онд багтаан зохион байгуулж, цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг ажлын хэсэг (С.Алтанцэцэг)-т даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Байгальмаа) -д үүрэг болгосугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ